



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 4/124

Номгон


Эргүүл хяналтын пост болон зарим аж ахуй  
нэгжүүдийн үйл ажиллагааны талаар авах  
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “б”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, “Онцгой комиссын ажиллах журам”-ын 1 дүгээр бүлгийн 1.6, аймгийн Засаг даргын 2021 оны А/02, А/119 дүгээр захирамж, аймгийн Онцгой комиссын 2021 оны 17 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдварын эрсдэлтэй бүс нутаг болох Улаанбаатар хотоос тусгай үүргийн автобус, хувийн автомашинаар ирсэн иргэдийн эхний ээлжийн эрүүл мэндийн тандалт судалгааг зохион байгуулж дууссантай холбогдуулан аймаг доторх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарлалтыг цуцалж, хэвийн горимд шилжүүлэн, хил залгаа аймгуудаас тус аймагт нэвтрэн орж ирдэг албан болон албан бус авто замууд дээр хяналтын постуудыг гаргаж бусад аймгуудаас нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Аймаг доторх зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэнтэй холбогдуулан зөвшөөрөгдсөн 14 салбарын үйл ажиллагаанаас гадна нийтийн хоол, цайны газрууд, зочид буудал, хүнс, барааны зах, үсчин, гоо сайхан авто засвар, дугуй засварын газар, барилгын материалын дэлгүүр, ерөнхий боловсролын сургуулийн төгсөх ангийн сурагчдын хичээлийн давтлага зэрэг үйл ажиллагааг нээсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

1210313